



АГУУЛГА

СӨРӨГ НӨЛӨӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ...	3
БИЕЛЭЛТ	3
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	5
БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА	6
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	6
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ	Error!
Bookmark not defined.	
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	Error! Bookmark not defined.
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ	
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ	Error! Bookmark not defined.
БИЕЛЭЛТ	Error! Bookmark not defined.
ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	7
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	8
2022 ОНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ	8
БИЕЛЭЛТ	8
ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	11
ДҮГНЭЛТ.....	12



2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дэвсгэрт орших MV-009623 тоот тусгай зөвшөөрлийн талбайтай “Цоохор морьт” алтны шороон ордыг ашиглах.

Төсөл хэрэгжүүлэгч:


Компаний нэр: “Өгөөжбаян хангай” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011300126

Регистрийн дугаар: 5515882 **Төслийн**

байршил:

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт хамаарагдах ба хамгийн ойр орших суурин газар нь Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум, “Монросцветмет” нэгдлийн Шижир алт үйлдвэрийн “Өгөөмөр” тосгон юм. Шижир алт үйлдвэрийн Өгөөмөр тосгон нь талбайгаас урагшаа 35 км-т, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум нь зүүн хойшоо 35 км-т тус тус оршдог.



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

Төслийн хүчин чадал, ажиллах горим Хүчин

чадал:

“Цоохор Морьт”-н алтны шороон ордыг ашиглах ил уурхайн хүчин чадлыг захиалагч байгууллагын санал, захиалагч байгууллагад бэлэн байгаа тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг үндэслэн жилд 150 мян.м³ элс олборлон угаахаар ТЭЗҮ-д тусгасан байна.

2022 онд нийт 2358.88 мян.м³ хөрс хуулж, 136.28 мян.м³ элс олборлосон.

СӨРӨГ НӨЛӨӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 1. Агаарт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /мян.төг/
1	Уурхайн олборлолтын үед тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авах	Тоосжилтоос сэргийлж зуны 3 сар өдөр бүр усалгаа хийж байсан. Бусад үед 7 хоногт 3 удаа усалгаа хийж байсан.	Дотоод төлөвлөлтөөр
2	Тоос шороотой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдыг тоосжилтоос хамгаалах зорилгоор өдөрт нормын сүү, цагаан идээгээр хангах	Тоос шорооной нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад сүү цагаан идээ тогтмол өгч байсан	600.0
3	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах	Тээврийн хэрэгсэлийн засвар үйлчилгээг байнга хийж байсан	Дотоод төлөвлөлтөөр
	Нийт		600.0

Хүснэгт 2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /мян.төг/
1	Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлүүлэх.	Ус ашиглалтын төлбөрийг цаг тухайд нь төлсөн.	-
	Гүний худгийн эргэн тойронд хамгаалалтын бүс тогтоож, хашиж, хамгаалах.	Худгийн эргэн тойронг хашиж хамгаалсан.	Дотоод төлөвлөлтөөр
2	Зуны улиралд аадар бохрооны үед үер болох нөхцөлтэй тул уурхай, овоолго зам талбай усанд автаж болзошгүй тул үерийн уснаас хамгаалах, усыг хатуу хог хаягдлаар бохирдуулахгүй байх	Зуны улиралд аадар бороо орсон үед уурхайн бүс усанл автхаас сэргийлж хамгаалалтын далан шуудуу татах арга хэмжээ авч ажилласан	Дотоод төлөвлөлтөөр

	хамгаалалтын далан шуудуу барих арга хэмжээ авах		
3	Ундны ус болон тунаах нуурын уснаас дээж авч лабораториор шинжлүүлэх	Унд болон тунаах нуурын уснаас 6, 9, 11 сард дээж аван мэргэжлийн байгуулгаар шинжлүүлсэн.	ОХШХ-нд зардал нь орсон.
4	Гүний худагт тоолуур тавих	Гүний худагийн хэрэглээг хянан ажилласан.	Үйл ажиллагааны зардалд орсон.
	Нийт		-

Хүснэгт 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /мян.төг/
1	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг Сайжруулах, нэмэгдүүлэх	Тээврийн хэрэгсэлийн зам дагуу таних тэмдэгүүдийг шинэчилж байршуулсан.	500.0
2	Өнгөн хөрсийг хуулан авах, уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах.	Хуулан авсан шимт хөрсөө уурхайн олборлолтонд өртхөөргүй талбайд овоолго хэлбэрээр хадгалж нөхөн сэргээлтэд ашигласан.	Дотоод төлөвлөлтөөр



3	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, хөрс, гүний ус бохирдохоос сэргийлэх, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах	ШТМ-ыг 25 тн-ы багтаамжтай 3ш ёнкост хадгалдаг. ШТМ асгарсан тохиолдолд байнга саармагжуулах арга хэмжээг авч ажилласан.	300.0
4	Шатах тослох материалыг хадгалах, түгээх цэгийг тохижуулж хяналтыг сайжруулах.	Шатах тослох материалыг хадгалах тусгай зориулалтын цэгийг тохижуулж хяналтыг сайжруулж ажилласан.	300.0
Нийт			1100.0

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Цоохор морьт” алтны шороон ордыг ашиглах явцад нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтонд өртсөн талбайд жил бүр хийх шаардлагатай. Нөхөн сэргээлтийн ажилд тусгай зардал төлөвлөн ажиллах бөгөөд уурхайн ашиглагдсан орон зайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

Шимт хөрсний овоолгыг хийхдээ “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” /MNS5916:2008/ стандартыг мөрдөн ажилласан.

Уурхайн эдэлбэр газрын нийт 417.97 га талбайгаас 2022 онд олборлолтонд хамрагдсан нийт 13 га талбай байна. 2021 он болон 2022 онд уулын ажилд өртсөн талбайн 10.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 5.4 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийсэн.

2022 онд биологийн нөхөн сэргээлтийн талбайд нэг наст ургамлаас арвай, судан олон наст ургамлаас цагаан арвай, хошоон, хүнцэгэ, согоовор, царгас зэрэг үрийг тарьсан. Нийт 325 кг үрийг худалдан авч биологийн нөхөн сэргээлтийг хийсэн. Үрийн ургалт ойролцоогоор 90%-тай байна.

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төлөвлөлтийн ажлын хэмжээ, га	Ажлын хэмжээ, га	Зардал /мян.төг/
---	-------------------------	-------------------------------	------------------	------------------



1	Техникийн нөхөн сэргээлт	7.0	10.1	Ашиглалтын зардалд тооцсон
2	Биологийн нөхөн сэргээлт	5.0	5.4	18700.0
Нийт		12	15.5	18700.0

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /мян.төг/
1	Цоохор морьтын уурхай дээрээ нөхөн сэргээлтийн ажлын сургалт зохион байгуулна.	Цар тахал болон эдийн засгийн хямрал нүүрэлж, түлшний үнэ нэмэгдэж зардал өссөнтэйгээр холбоотой тус ажил хийгдэж чадаагүй	-
2	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Булган аймгийн Бүрэгхангай сумын шивэрт голын орчим 3.15 га талбайд мод тарьж хашаажуулхаар төлөвлөсөн. Зардлыг дотоод төлөвлөлтөөр	Булган аймгийн Бүрэгхангай сумын шивэрт голын орчим 3.15 га талбайг хашаажуулан 800 мод тарьсан	Дотоод төлөвлөлтөөр
Нийт			-



ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Өгөөж баян хангай” ХХК-ны ажилчид маань энэ онд аюулгүй ажилгааны зааварчилгаа ХАБЭА заавар зөвөлгөө зөвлөмжийг ном дүрмийн дагуу мөрдөж ажилласан.

Хүснэгт 5. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /мян.төг/
1	Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулан, Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж ажилласан.	600.0
2	Хүчтэй салхи шуурганы улмаас тоос ихээр босч ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, тоосжилтоос үүсэх бусад нөлөөлөл	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох арга хэмжээ авч ажилласан	-
3	Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал, цахилгаан тасрах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед уурхайн ажлыг түр зогсоох арга хэмжээ авч ажилласан	-
4	Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар ИТА ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт хийсэн	1040.0
5	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж, бэртээх гэх мэт осол аваар гарах	Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулан, жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан.	500.0
	Нийт		2140.0



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам болон үйлдвэрлэлийн хэрэгцээтэй газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь хэтэрхий удаан байдаг учраас байгаль орчинд хамгийн их хор хөнөөлтэй. “Өгөөжбаян хангай” ХХК нь Хог хаягдалын төлбөр хураамжийг цаг тухай бүрт нь бүрэн гүйцэт төлсөн.

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /мян.төг/
1	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгийг Бүрэгхангай сумын засаг даргаар тогтоолгосны дагуу төвлөрсөн цэгт хогийг тухай бүрт тээвэрлүүлэх	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгт хогийг тухай бүрт тээвэрлүүлэн хаяж байсан	500.0
2	Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлыг хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах, ангилсан хаягдлыг агуулах нэмэлт хогийн савнууд суурилуулж, тэмдэгжүүлэх	Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлыг хаях нэмэлт хогийн савнууд суурилуулсан.	300.0
3	Ахуйн бохир ариутгаж халдваргүйжүүлэх “тамир эм” бэлдмэлийг хэрэглэх	Ахуй бохирыг тухай бүрт ариутгаж халдваргүйжүүлэн ажилласан	500.0
4	Дахин ашиглагдах түүхий эдийг бусад хог хаягдлаас ялган хоёрдахь түүхий эд авдаг газар аваачиж тушаах	Дахин ашиглах боломжтой хог хаягдалыг тусад ангилан ялгаж хаядаг	-
	Нийт		1300.0

2022 ОНЫ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Өгөөжбаян хангай” ХХК нь 2022 оноос “Байгаль орчны мэргэжилтэн” гэсэн ажлын байр бий болгон ажиллахаар төлөвлөж байгаа билээ. Байгаль орчны мэргэжилтэн нь



байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллана.

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /мян.төг/
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын дотоод журам боловсруулж мөрдөн ажилласан.	-
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар ОБЕГ-ын УУА 09-р ангийн мэргэжилтнүүдээр бүх ажилчиддаа сургалт зохион байгуулсан	2000.0
3	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн талаар сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн талаар сургалт, семинарыг дотоодоо тогтмол зохион байгуулсан.	-
4	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулсан	Дотоод төлөвлөлтөөр.
5	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах.	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан.	Дотоод төлөвлөлтөөр
6	Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах	Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангаж, галыг унтраах талаар арга хэмжээ зохион байгуулсан	Осол эрсдэлийн төлөвлөгөөнд орсон.



	талаар арга хэмжээ зохион байгуулах		
7	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг бэлтгэж, шаардлагатай газруудад байрлуулах	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгслийг уурхайн эмчийн байранд байршуулан ажилласан	500.0
8	Байгаль орчны аудит хийлгэх	Энэ хийгдэх жил болоогүй 2 жил 1 удаа учир	-
9	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Нутгийн иргэдэд хөрзөн хуулж өгөх мөн малчдад малын угаалгын банн зэргийг хийж өгсөн	Дотоод төлөвлөлтөөр
	Нийт		2500.0

ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Өгөөжбаян хангай” ХХК-ийн “Цоохор морьт” алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй нөлөөлөлд шууд өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, БОМТ, түүний биелэлтийг тайлагнах үүргээ хэрэгжүүлэх зоригтой дараахь арга хэмжээг төлөвлөж, биелүүлэн ажиллаж байна.



Хүснэгт 9. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Мэдээллийн агуулга	Биелэлт	Зардал /мян.төг/
Булган аймаг, Бүрэг хангай сум, Дэрст багын ИНХ	БОМБТБТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	Булган аймаг, Бүрэгхангай сум, Дэрст багын ИНХ 7-р сард танилцуулсан	Дотоод төлөвлөлтөөр
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны засаг дарга, байгаль орчны ТББ	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	11-н сарын 7-нд танилцуулна	Дотоод төлөвлөлтөөр
БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12 сарын 1-нээс өмнө хүргүүлнэ.	Дотоод төлөвлөлтөөр

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Зардал /мян.төг/
1	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрс устөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол). Унд ахуйн усыг хангаж буй гүний уснаас, тунаах нуураас жилд 2 удаа	Тунаах нуур, унд ахуйн уснаас 6, 9, 11 саруудад дээж аван Газарзүй, Гео-эко хүрээлэнд өгч шинжлүүлсэн.	46.0*3=138.0
2	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр. Төслийн талбайд 2 цэг сонгох. /овоолго болон олборлолт явуулж буй талбайн ойролцоо/ жилд 2 удаа	Уурхайн кэмп, уурхай, уурхайн 00 орчимоос 6, 9, 11 саруудад дээж аван Газарзүй, Гео-эко хүрээлэнд өгч шинжлүүлсэн.	60.0*3=180.0
	Нийт		318.0



ДҮГНЭЛТ

“Өгөөжбаян хангай” ХХК-ний Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших “Цоохор морьт” алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд 2022 онд нийтдээ 26658.0 сая.төг зарцуулсан байна.

Энэхүү алтны шороон ордод олборлолтын үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл болон олборлолтын үйл ажиллагаанаас эвдэрсэн хөрсийг цаг тухай бүрт нь нөхөн сэргээлт хийж, ургамлан нөмрөгийг байгалийн аясаар ургах нөхцөлийг бүрдүүлэн олон наст ургамалын үрийг тарьж ургуулсан.

Хүснэгт 10. Нийт зардлын хүснэгт

№	Арга хэмжээ	Зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	1700.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	18700.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
4	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	2140.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	1300.0
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	2500.0
7	Олон нийтэд тайлагнасан тухай биелэлт	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт	318.0
	Нийт дүн	26658.0

ХАВСРАЛТ



Зураг 2. Усалгаа хийж байгаа байдал



Зураг 3. Үерийн уснаас хамгаалах шуудуу




Зураг 4. Таних тэмдэгүүд



Зураг 5. ШТМ хадгалах ёнкос



Зураг 6. Техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал



Зураг 7. Биологийн нөхөн сэргээлт хийхээс өмнөх байдал



Зураг 8. Биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байдал



Зураг 9. Галаас хамгаалах хэрэгсэл байршуулсан байдал



Зураг 10. Галын хор ашиглах талаарх сургалт зохион байгуулж байгаа байдал



Зураг 11. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангагдсан байдал



Зураг 12. ХАБЭА-н сургхлт хийж байх үеийн зураг



Зураг 13. Хог хаягдлын цэгийг тойруулан хашсан байдал



Зураг 14. Хэрэглэсэн тос масло хадгалах газар



Зураг 15. Багийн ИНХ-д тайлагнаж байгаа байдал

